



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 05 сарын 13 өдөр

Дугаар А/274

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн 2020 оны Замын сангийн хөрөнгө оруулалтын жагсаалтын 4.2 заалтад тусгагдсан “Авто замын трасст орсон айлын газар чөлөөлөлтийн зардал”- г Жаргалант сумын Наран багийн 19-06 тоот, өмчлөх эрх бүхий 1088 метр квадрат газраас 544 метр квадрат газрыг аймгийн Засаг даргын 2020 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн А/215 дугаар захирамжаар нийтийн эзэмшилд авсан тул газрын эзэн, иргэн Д.Норжмаа, С.Цэрэндулам нарт газар чөлөөлөлтийн зардлыг олгосугай.

2.Дээрх төсөл арга хэмжээнд Замын сангийн хөрөнгөөс зарцуулагдах 50 000 000 төгрөг /Тавин сая/ - ийг санхүүжүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Б ДҮГЭРЖАВ

